



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 39,700,000.00 (гучин есөн сая долоон зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоож, Зэвсэгт хүчний 089 дүгээр ангид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнгийн захирал Б.Даваадорж, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 05 дугаар сарын 05-ны/ний өдрийн  
 095 дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН СТРАТЕГИ СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
 БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 089 ДҮГЭЭР АНГИД БАЛАНСААС БАЛАНСАД  
 ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар   | Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл/ төгрөг/ | Цаашид ашиглах жил /тоогоор/ /төгрөг/ | Шинэчлэн тогтоосон үнэ /төгрөг/ |
|-----|---|------------------------------------|-----------------|--|---------------------------------------|---------------------------------|
|     |   |                                    |                 |  |                                       |                                 |
| 1   | Тоёото хайландр автомашин 92050019, улсын дугаар 6611 УНТ | 2009/2012                          | 184,911         | 39,700,000.00                                | 5                                     | 10,000,000.00                   |
|     |   |                                    |                 | 39,700,000.00                                |                                       | 10,000,000.00                   |
|     |   |                                    |                 | (гучин есөн сая долоон зуун мянган)          |                                       | (арван сая )                    |